

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 08 сарын 17 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж” дахь заалтыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн парк хөгжүүлэх” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөг боловсруулан, жил бүрийн эдийн засаг, нийгмийн зорилт болон төсөвт тусган ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба /Б.Энхболд/-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАТТУЛГА

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2015 оны 08 дугаар сарын
17 –ны өдрийн 133 дүгээр тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Үндэслэл шаардлага

Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 26/08 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын Эдийн засгийн хөгжлийн стратеги” баримт бичигт Нийслэл Улаанбаатар хотын дагуул хот, тосгодод үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж хөгжүүлэхээр тусгагдсан.

Мөн түүнчлэн Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолоор арьс ширний анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг 2017 оны 12 сарын 31-ний дотор үе шаттайгаар Улаанбаатар хотоос нүүлгэхээр шийдвэрлэсний дагуу Засгийн газрын 2014 оны 356 дугаар тогтоолоор Хан-Уул дүүргийн 13-р хорооны нутаг Шар хөцийн хоолойд арьс ширний анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг, Засгийн газрын 2012 оны 171-р тогтоолоор баталсан “Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-т Нийслэл Улаанбаатар хотын дагуул хот, тосгодод барилгын материалын үйлдвэрүүдийг, Засгийн газрын 2011 оны 104 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад Багануур хотод нүүрс-хими технологийн үйлдвэрүүдийг төвлөрүүлэн байршуулж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар тус тус заасан.

Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг саармагжуулах, үйлдвэрүүдийг кластер хэлбэрээр хөгжүүлэх, агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах, ундны усны нөөцийг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлыг түргэвчлэх шаардлага гарч байна.

Улсын болон нийслэлийн төсвөөр Эмээлтийн үйлдвэрлэл, технологийн паркийн, Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн, Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Техник эдийн засгийн үндэслэлийг 2011-2014 онуудад боловсруулаад байна

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу нийслэл хотоос үйлдвэрлэл, технологийн паркуудын байршил, газрын хэмжээг тогтоон “Эмээлтийн Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”, “Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газруудыг тус тус байгуулан үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтыг улс, нийслэлийн төсөв болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.

Эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0,3 хувийг эзэлж, хүн амын 46.8 хувь буюу 1 372 000 хүн ажиллаж амьдарч, хүн амын нягтралаараа хамгийн өндөр хот хэвээрээ байна.

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64.5 хувийг нийслэл хот бүрдүүлж байгаа бөгөөд эдийн засгийг салбараар авч үзвэл 68.8 хувийг үйлчилгээний, 30.7 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 0.5 хувийг хөдөө аж ахуйн салбар байна.

Өнөөдрийн байдлаар нийслэлд бүх салбарын үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүд Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд голлон төвлөрч байгаагийн улмаас зарим талаараа иргэдийн аюулгүй, ая тухтай орчинд амьдрахад сөргөөр нөлөөлж байна. Өнгөрсөн хугацаанд хаягдал төмөр дахин боловсруулах үйлдвэрүүдийг захын дүүргүүд рүү тодорхой байршилд нүүлгэн шилжүүлсэн боловч барилгын материалын үйлдвэрүүдийн талаар иргэд гомдол гаргах болсон. Эдгээр үйлдвэрүүдийн одоогийн байршилтай зэрэгцэн иргэд суурьших болсон нь шийдвэрлэх асуудлуудын нэг болоод байна. Үйлдвэрүүдээс гарч байгаа технологийн хаягдал нь Улаанбаатар хотын байгаль орчинд сөрөг нөлөөллийг бий болгож байгаа учир хүн, малын эрүүл мэндэд халгүй, агаар, хөрс, усанд ямар нэгэн бохирдолгүй цэвэр үйлдвэрлэл явуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл элдэв төрлийн хорт хий, эвгүй үнэр, аэрозол, лаг, хатуу, шингэн хаягдал буюу бохир усыг байгальд хаяхгүй байх, стандартын шаардлагыг бүрэн хангах, дэвшилтэт технологийг нэвтрүүлж ажиллах явдал чухлаар тавигдаж байна.

Хоёр. Үйлдвэрлэл, технологийн паркийн хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1 Хөтөлбөрийн зорилго

Нийслэл хотод байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий экспортын чиглэлийн болон импортыг орлох үйлдвэрлэлийг паркийн хэлбэрээр хөгжүүлэх замаар нийслэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, эдийн засгийн зохистой бүтцийг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилтууд

Хөтөлбөрийн зорилгыг дараах зорилтуудаар хэрэгжүүлнэ.

2.2.1 Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих, бизнесийн таатай орчин бүрдүүлэх;

2.2.2 Хөрөнгө оруулагчдыг татах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх;

2.2.3 Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, үйл ажиллагаа, хяналтын тогтолцоог төлөвшүүлэх;

2.2.4 Бүтээн байгуулалтад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

2.2.5 Дэд бүтэц, үндсэн барилга байгууламжуудыг барьж байгуулах;

2.2.6 Паркийн хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх;

2.2.7 Өндөр технологийн судалгаа, R&D болон инновацийг дэмжих;

2.2.8 Жижиг дунд үйлдвэрийг чадавхижуулах;

2.2.9 Худалдааг дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үе шатууд

3.1 Эхний үе шат: 2015-2016 он

Энэ үе шатанд хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг парк тус бүрээр гаргаж, бэлтгэл ажлыг бүрэн ханган эхний шатны хөрөнгө оруулалтыг хийж үйлдвэрлэл, технологийн паркийн бэлтгэл ажил хийгдэж дуусна.

3.2 Хоёрдахь үе шат: 2017-2020 он

Энэ үе шатанд гэрээний дагуу хөрөнгө оруулалтууд хийгдэж үйлдвэрлэлийн болон бусад нэгжүүдийн бүтээн байгуулалтын ажил бүрэн хийгдэнэ. Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдэрч, бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлнэ.

3.3 Гуравдахь үе шат: 2021-2025 онд

Энэ үе шатанд үйлдвэрлэл, технологийн парк бүрэн утгаараа ажиллаж, Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, шинжлэх ухаан - үйлдвэрлэлийн цогцолборын суурь тавигдана.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжих байршил

4.1 Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк;

4.2 Налайх хотын 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк;

4.3 Багануур дүүрэгт нүүрс-хими технологийн үйлдвэрлэл, технологийн парк;

4.4 Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд дахин боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйлдвэрлэл, технологийн парк;

4.5 Хотын ерөнхий төлөвлөлтийн дагуу байгуулагдах үйлдвэрлэл, технологийн парк.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийг дэмжих, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1 Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, татварын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудын заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах;

5.1.2 Паркт байрших үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудад хуулиар заагдсан хөнгөлөлт, татварын бус дэмжлэг үзүүлэх журмуудын санал боловсруулах;

5.1.4 Паркийн инженерийн дэд бүтэц, зам талбайг барихад оруулсан хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлөх болон бусад татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой журмын санал боловсруулах;

5.1.5 Паркийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах;

5.1.6 Паркт байрших үйлдвэрлэлийн чиглэл, байрших үйлдвэрүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулан батлуулах.

5.2 Хөрөнгө оруулагчдыг татах, хамтын ажиллагааг идэвхижүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.2.1 Хөрөнгө оруулагчидтай хөрөнгө оруулалтын болон тогтвортой байдлын гэрээ байгуулахад дэмжлэг үзүүлэх;

5.2.2 Гадаадын өндөр технологийн компанийг татах;

5.2.3 Патент, лицензийн үйлчилгээг төрийн захиргааны байгууллагуудтай хамтран шуурхай үзүүлэх;

5.2.4 Дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг паркийн дэд бүтэц, үндсэн барилга байгууламжуудын бүтээн байгуулалтанд татан оруулах;

5.2.5 Гадаадын зөвлөх багтай хамтран ажиллах, олон улсын худалдааны сүлжээг нэвтрүүлэх.

5.3 Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, үйл ажиллагаа, хяналтын тогтолцоог төлөвшүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.3.1 Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдах зөвлөлийг байгуулах;

5.3.2 Паркийн тогтвортой хөгжлийг хангахуйц үйлдвэрлэл, маркетинг, санхүү, мэдээллийн болон тээвэр логистикийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгон төлөвшүүлэх;

5.3.3 Паркийн эрсдлийн удирдлагын болон хяналт, мониторингийн үр дүнтэй тогтолцоог бий болгон төлөвшүүлэх;

5.3.4 Паркийн хөгжлийг тодорхойлохуйц шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хамгийн үр ашигтайгаар явуулж чадахуйц зөөлөн дэд бүтцийг бий болгох.

5.4 Бүтээн байгуулалтад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.4.1 Паркийг байгуулахад шаардлагатай хөрөнгийг босгох төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын санал, концессын гэрээний нөхцлүүдийг боловсруулж батлуулах;

5.4.2 Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар олгогдсон газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар дэд бүтцийг байгуулахад шаардлагатай хөрөнгийг босгох.

5.5 Дэд бүтэц, үндсэн барилга байгууламжуудыг барьж байгуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.5.1 Паркийн дэд бүтэц, авто болон төмөр зам, тээвэр, ложистикийн сүлжээг хамгийн өндөр үр ашигтай байхаар зохион байгуулах;

5.5.2 Паркт байрших үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагуудыг тогтвортой, тасралтгүй цахилгаан, дулаан, уур, усаар хангах дэд бүтцийн найдвартай эх үүсвэрийг барьж байгуулах;

5.5.3 Байгаль орчинд ээлтэй Эко парк байгуулах үүднээс паркийн хог хаягдлыг дахин боловсруулах сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий байгууламжийг барих.

5.6 Паркийн хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.6.1 Паркийн удирдлага болон паркт байрших нэгжүүдийг чадварлаг боловсон хүчнээр тасралтгүй хангах, хөгжүүлэх, чадавхижуулах, мэргэшүүлэх үүднээс гадаад дотоодын төрийн ба төрийн бус байгууллагууд, сургалт эрдэм шинжилгээний байгууллагуудтай харилцан ашигтайгаар хамтран ажиллах тогтолцоог бий болгох;

5.6.2 Паркийн нэгжүүд хоорондоо туршлага солилцох, ажил сэлгэлт хийх, ажлын байран дахь сургалт зохион байгуулах зэргээр мэргэжилтний сүлжээг хөгжүүлэх;

5.6.3 Паркт ажиллах хүчний нийгмийн дэд бүтэц, үйлчилгээг онцгой анхааран, хүнд чиглэсэн, эрүүл, аюулгүй, таатай хөдөлмөрлөх орчинг бүрдүүлэх.

5.7 Өндөр технологийн судалгаа, R&D болон инновацийг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.7.1 Паркт байрших үйлдвэр, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

5.7.2 Аж ахуйн нэгжийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход чиглэсэн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар хувийн хэвшлийн R&D дэмжих;

5.7.3 Технологийн ололт амжилтыг патентжуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгоход төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах;

5.7.4 Өндөр технологи, ноу хау, инноваци шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах.

5.8 Жижиг дунд үйлдвэрийг чадавхижуулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.8.1 Инкубаторын үйл ажиллагааг явуулах;

5.8.2 Хоршин ажиллах зарчимд тулгуурлан, бойжигчдыг зах зээлд гаргахад дэмлэг үзүүлэх, кластерын хэлбэрээр хөгжүүлэх.

5.9 Худалдааг дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.9.1 Паркт байрших нэгжүүд худалдан авагчид, түншүүдтэйгээ харилцах, үйл ажиллагаагаа сурталчлан таниулахад таатай, тухтай, үр ашигтай байх үйлчилгээний дэд бүтцийг бий болгох;

5.9.2 Бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд сурталчлахад чиглэсэн үзэсгэлэн, бизнес уулзалтуудыг зохион байгуулах;

5.9.3 Төсвийн худалдан авалтад нэн тэргүүнд паркад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

6.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

6.1.1 Улсын болон орон нутгийн төсөв

6.1.2 Засгийн газрын болон Нийслэлийн бонд

6.1.3 Гадаад, дотоодын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө оруулалт

6.1.4 Гадаад улс, олон улсын буцалтгүй тусламж, хандив

6.1.5 Бусад

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт

7.1 Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавина.

7.2 Нийслэлийн Засаг даргын үйлдвэрлэлийн асуудал хариуцсан хэрэгжүүлэгч агентлаг хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

7.3 Агентлаг нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар хагас болон бүтэн жилээр тайлагнана.

7.4 Агентлаг нь холбогдох байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийнэ.

Найм. Хөтөлбөрийн үнэлгээ

8.1 Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:

8.1.1 Эхний үе шат болох 2015-2016 онуудад үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн шугам, сүлжээ, барилга байгууламж, зам талбайн зураг төслийн ажлууд хийгдэж дуусна.

8.1.2 Хоёрдахь үе шат болох 2017-2020 онуудад Нийслэлийн Хан-Уул дүүргийн 13-р хороо Шар хөцийн хоолойд Эмээлтийн Хөнгөн үйлдвэрлэл технологийн парк, дагуул хотууд болох Багануур дүүрэгт Үйлдвэрлэл технологийн парк, Налайх хотод Барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркууд байгуулагдаж гэрээний дагуу хөрөнгө оруулалтууд хийгдэж үйлдвэрлэлийн болон бусад нэгжүүдийн бүтээн байгуулалтын ажил бүрэн хийгдэнэ. Зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдэрч, бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлнэ.

Нийслэлд шинээр 30.0 мянган ажлын байр нэмэгдэж, нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ өснө.

8.1.3 Гуравдахь үе шат 2021-2025 онуудад үйлдвэрлэл, технологийн паркийн төмөр зам, авто замын бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусна.

-----oOo-----